

МХБХ-ны Зөвлөлийн 2024 оны
01 дүгээр сарын 19-ний өдрийн
хурлын №. тоот тогтоолоор батлав.



**“МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ
ОРОН НУТГИЙН ГИШҮҮН ХОЛБООД”-ЫН
ЖИШИГ ДҮРЭМ**

ДАРААХ НЭР ТОМЬЁОГ ДОР ДУРДСАНААР ОЙЛГОНО:

ОУХБХ: “Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо”;

АХБХ: “Азийн Хөлбөмбөгийн Холбоо”;

ЗАХБХ: “Зүүн Азийн Хөлбөмбөгийн Холбоо”;

МХБХ: “Монголын Хөлбөмбөгийн Холбоо”, Олон улсын хөлбөмбөгийн холбоо, Азийн хөлбөмбөгийн холбооноос гишүүнээр хүлээн зөвшөөрөгдсөн холбоо;

Холбоо: “МХБХ-ны орон нутгийн гишүүн холбоо”, МХБХ-ноос гишүүнээр хүлээн зөвшөөрөгдсөн хөлбөмбөгийн холбоо, МХБХ-нд захирагдах байгууллага;

Клуб: МХБХ-ны гишүүн Холбооноос хүлээн зөвшөөрсөн гишүүн;

Тоглогч: Холбоонд бүртгэлтэй хөлбөмбөгийн тоглогч;

Холбооны гишүүдийн хурал: Холбооны эрх барих дээд байгууллага;

Зөвлөл: Холбооны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох байгууллага;

Гишүүн: Холбооны гишүүдийн хурлаас Холбооны гишүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн хувь хүн болон хуулийн этгээд;

Холбооны тэмцээн уралдаанууд: МХБХ-ноос хяналт тавьж, Тоглолтын Дүрэмд заасны дагуу зохион байгуулагдах тэмцээн;

Тоглолтын Дүрэм: ОУХБХ-ны хөлбөмбөгийн холбоодын Зөвлөл, МХБХ-ны дүрэм болон зохих журмын дагуу боловсруулсан хөлбөмбөгийн тоглолтын дүрэм;

Монголын Олон улсын ба Үндэсний спортын Арбитр: Монгол газар нутаг дээр маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх эрх бүхий, МХБХ-нд хүлээн зөвшөөрөгдсөн, хуулийн дагуу байгуулагдсан бие даасан байгууллага;

Спортын Арбитрын Шүүх (САШ): Швейцарь Улсын Лозанна хотод байрладаг Спортын Арбитрын Шүүх.

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1-р зүйл Нэр төв байр болон хуулийн этгээдийн хэлбэр

1. аймгийн хөлбөмбөгийн холбоо (цаашид “Холбоо” гэх) нь Монголын хөлбөмбөгийн холбооны дүрмийг дагуу удирдлага болгон үүсгэн байгуулагдсан, аймгийн хуулийн этгээдийн бүртгэлийн газарт нэрээр бүртгэгдсэн, цаашид Монгол улсын холбогдох хууль тогтоомж, МХБХ-ны дүрэм болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах, нийгэмд үйлчилдэг Төрийн бус байгууллага мөн.
2. Холбоо нь Монголын Хөлбөмбөгийн Холбооны гишүүн байгууллагаар бүртгүүлнэ.
3. Холбооны албан ёсны хаяг:
 - Аймаг, хот :
 - Сум дүүрэг :
 - Баг хороо :
 - Оршин байх хаяг:
 - Шуудангийн хайрцагны №
 - Е майл хаяг :
 - Харилцах утас : 1 2.
4. Холбоо нь өөрийн лого, албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга тэмдэгтэй байх бөгөөд тэдгээр нь МХБХ-ноос баталсан өгөөн загварын дагуу байна. Холбооны туг, бэлгэ тэмдэг нь хавсралт №1-т заасны дагуу байна.
5. Холбоо нь МХБХ-ноос баталснаас өгөөнөө өөр загварын тамга тэмдэг, лого, албан бичгийн хэвлэмэл хуудас ашигласан тохиолдолд тэдгээр нь хүчин төгөлдөр бус байна.
6. Холбооны үйл ажиллагаа нь МХБХ-ны гишүүдэд ил тод байх бөгөөд холбоо нь цахим хуудастай байж болно.

2-р зүйл Холбооны зорилго, үйл ажиллагаа

1. аймгийн хөлбөмбөгийн холбоо нь дараах зорилготой байна. Үүнд:
 - 1.1 Өөрийн аймаг, орон нутагтаа МХБХ-ны нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх,
 - 1.2 Хөлбөмбөгийн спортыг орон нутагтаа хөгжүүлэх, спортын эв нэгдэл, боловсрол, соёл болон хүмүүнлэгийн ач холбогдлыг аймаг, орон нутагтаа сурталчлан таниулах,
 - 1.3 Мэргэжлийн дасгалжуулагч, тамирчдыг бэлтгэх, орон нутаг цаашлаад бүс, улсын болон олон улсын чанартай тэмцээнүүдэд амжилт гаргах нөхцлийг бүрдүүлэх,
 - 1.4 Аймагтаа аймгийн чанартай хөлбөмбөгийн тэмцээн, уралдааныг зохион байгуулах,
 - 1.5 Холбооны гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах,
 - 1.6 Холбоо нь улс төр, шашны асуудлаар төвийг сахисан байр суурьтай байх ба өөрийн гишүүдийг төвийг сахисан байлгах.
2. Холбоо нь энэхүү дүрэмд заагдсан зорилгоо хэрэгжүүлэх үүднээс доорх үйл ажиллагааг явуулна. Үүнд:
 - 2.1 МХБХ-той нягт уялдаа холбоотой ажиллах,
 - 2.2 МХБХ-ноос зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд орон нутгаа төлөөлөн оролцох,
 - 2.3 МХБХ-ны дүрэм, журмыг сурталчилан таниулах, өөрөө болон өөрийн гишүүдээр түүнийг сахин мөрдүүлэх, холбогдох журам, зааврыг аймагтаа боловсруулан баталж, хэрэгжилтийг хангах,

- 2.4 ОУХБХ, АХБХ, МХБХ-ны Дүрэм, журам, шийдвэр болон Тоглолтын дүрэм зөрчигдөхөөс сэргийлж, шаардлагатай арга хэмжээ авах замаар гишүүд болон хөлбөмбөгийн тоглолтод хяналт тавих,
- 2.5 Хөлбөмбөгийн спортын ёс зүй, соёл, эв нэгдэл, хөлбөмбөгийн шударга тоглолтын талаар өөрийн гишүүдэд таниулан сурталчлах,
- 2.6 Аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдах хөлбөмбөгийн бүх төрлийн тэмцээн, нөхөрсөг тоглолтод хяналт тавьж, удирдлагаар хангах,
- 2.7 МХБХ-ны тухайн жилийн үйл ажиллагааны зорилго, зорилтод нийцүүлэн бусад үйл ажиллагаа зохион байгуулах,
- 2.8 Засаглалын сайн зарчмыг сахин хамгаалж, аймгийн нутаг дэвсгэртээ өөрийн гишүүдээр сахин мөрдүүлэх,
- 2.9 Эмэгтэй хөлбөмбөгийн хөгжлийг дэмжиж бүхий л түвшинд эмэгтэй хөлбөмбөгийн оролцоог бүрэн хангахын төлөө ажиллах.

4-р зүйл. Үл ялгаварлан гадуурхах

1. Арьс өнгө, үндэс угсаа болон нийгмийн гарал, хүйсийн ялгаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон бусад үзэл бодол, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, эд хөрөнгө, нас, хүйсийн чиг хандлага, харагдах байдал зэрэг шалтгаанаар улс орон, хувь хүн эсвэл бүлэг хүмүүсийг ялгаварлан гадуурхах аливаа явдлыг хатуу хориглож, ийм явдал гаргавал гишүүнээс түдгэлзүүлэх, чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

5-р зүйл. Төвийг сахих ба хараат бус байдал

1. Холбоо нь улс төр, шашны асуудлаар төвийг сахисан байр суурь баримтална.
2. Холбооны гишүүд нь улс төр, шашны асуудлаар төвийг сахисан байр суурьтай байх ба өөрийн гишүүдийг төвийг сахисан байлгана.
3. Холбоо нь улс төрийн оролцооны аливаа хэлбэрт үл автаж хараат бус байна. Өөрийн асуудлаа бие даасан хараат бусаар шийдвэрлэж гуравдагч этгээдийн нөлөөнд автахгүй явуулна.
4. Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж Холбооны бүтцийн байгууллагын гишүүд өөрт хамааралтай асуудлыг шийдвэрлэхэд оролцохгүй байна.

6-р зүйл. Тоглогч

1. ОУХБХ-ны Тоглогчийн статус ба шилжилт хөдөлгөөний журамд нийцүүлэн МХБХ-ноос баталсан Тоглогчийн эрх зүйн байдал ба шилжилт хөдөлгөөний журмыг дагаж мөрдөнө.
2. Тоглогчдыг МХБХ-ны журмын дагуу бүртгэх ба шилжүүлнэ.

7-р зүйл. Тоглолтын дүрэм

1. Холбоо, түүний гишүүд нь Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс баталсан “Тоглолтын дүрэм”-ийн дагуу холбооны тэмцээн уралдаанд оролцоно. “Тоглолтын дүрэм”-ийг гагцхүү Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс (IFAB) тогтоох ба өөрчилнө.

2. Холбоо болон түүний гишүүд футзал, элсний хөлбөмбөгийг Футзалын “Тоглолтын Дүрэм” болон Элсний хөлбөмбөгийн “Тоглолтын Дүрэм”-ийн дагуу тоглоно. Футзалын болон Элсний хөлбөмбөгийн Тоглолтын Дүрмүүдийг зөвхөн ОУХБХ-ноос тогтоох ба өөрчилнө.

8-р зүйл. Байгууллага, албаны хүмүүсийн ёс зүй

1. Холбооны байгууллагын гишүүд болон албаны хүмүүс нь үйл ажиллагаандаа ОУХБХ, АХБХ, МХБХ болон Холбооны Дүрэм, журам, шийдвэр, зааварчилга болон Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.

9-р зүйл. Албан ёсны хэл

1. Холбооны албан ёсны хэл нь Монгол хэл байна.
2. Холбооны гишүүдийн хурлын албан ёсны хэл Монгол хэл байна.

II. ГИШҮҮНЧЛЭЛ

10-р зүйл. Холбооны гишүүнчлэл

1. Холбоо нь дараах гишүүдээс бүрдэж болно. Үүнд:
 - 1.1 Орон нутгийн сумд болон аймгийн төвийн төлөөлөл,
 - 1.2 Орон нутгийн клубүүдийн төлөөлөл,
 - 1.3 Дасгалжуулагчдын төлөөлөл
 - 1.4 Шүүгчдийн төлөөлөл
 - 1.5 Эмэгтэй хөлбөмбөгчдийн төлөөлөл
 - 1.6 Ахмад хөлбөмбөгчдийн төлөөлөл
 - 1.7 Орон нутаг дахь хөлбөмбөгийн элч төлөөлөгч,
 - 1.8 Спортын мэргэжилтэн
2. Холбоонд гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх болон гишүүнчлэлээс чөлөөлөх асуудлыг Холбооны гишүүдийн хурал шийдвэрлэнэ. Холбоонд гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх болон гишүүнчлэлээс чөлөөлөх үйл ажиллагааг энэхүү дүрэм болон Зөвлөлөөс баталсан журмаар тодорхойлно.
3. МХБХ болон Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрч, МХБХ болон Холбооноос тавьсан шаардлагыг хангасан тохиолдолд гишүүнээр элсүүлж болно.
4. Гишүүнээс татгалзсан эсхүл гишүүнээс чөлөөлөгдсөн тохиолдолд гишүүнчлэлийг дуусгавар болгоно. Гишүүнчлэлээ алдсанаар уг гишүүний Холбоонд хамаарах бүхий л эрх дуусгавар болох боловч энэ нь гишүүн байхдаа Холбоо болон Холбооны бусад гишүүний өмнө хүлээсэн санхүүгийн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

11-р зүйл. Гишүүнээр элсүүлэх

1. Холбооны гишүүнээр элсэх хүсэлтэй, энэ дүрмийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хүн, хуулийн этгээд нь Холбооны нарийн бичгийн даргад бичгээр хүсэлт болон шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж өгнө.
2. Хүсэлтэд дараах материалыг хавсарган өгнө. Үүнд:
 - 2.1 Холбооны гишүүнээр элсэх өргөдөл,

- 2.2 Хүсэлт гаргагч хувь хүний иргэний үнэмлэх, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
 - 2.3 Хүсэлт гаргагчийн танилцуулга,
 - 2.4 ОУХБХ, АХБХ, МХБХ болон Холбооны дүрэм, журам, шийдвэр, Тоглолтын дүрэм зэргийг дагаж биелүүлэх амлалт,
 - 2.5 ОУХБХ, АХБХ болон Холбооны дүрэм, журам, шийдвэр болон зааврыг тайлбарлах, хэрэглэх асуудлаар Шүүхэд хандахгүй гэсэн амлалт;
 - 2.6 Энэ Дүрэмд заасан Швейцарийн Лозанн хотноо төвтэй Олон улсын спортын арбитрын шүүхийг (CAS) эсвэл МХБХ-ны хүлээн зөвшөөрсөн үндэсний арбитрыг хүлээн зөвшөөрч байгаа тухай мэдэгдэл,
3. Холбоонд элсэхээр хүсэлт гаргагчийг гишүүнээр элсүүлэхийг зөвшөөрсөн Холбооны гишүүдийн хурлын тогтоол гарснаар гишүүний эрх, үүрэг үүснэ.

12-р зүйл. Гишүүний эрх

1. Холбооны гишүүн нь дараах эрхтэй. Үүнд:
 - 1.1 Холбооны гишүүдийн хуралд оролцох, хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцах, товлосон хугацаанд Холбооны гишүүдийн хуралд дуудагдах, санал өгөх эрхээ эдлэх,
 - 1.2 Холбооны гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах,
 - 1.3 Холбооны Зөвлөл, Тэргүүнд нэр дэвшүүлэх,
 - 1.4 Холбооны үйл ажиллагааны талаар тус холбооны эрх бүхий байгууллагаас мэдээлэл авах,
 - 1.5 Холбооноос зохион байгуулж буй бүхий л тэмцээн, уралдаан болон спортын бусад арга хэмжээнд оролцох,
 - 1.6 МХБХ болон Холбооны дүрэм, журамд заасан бусад эрх.
2. Дээр дурдсан эрхийг хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийн бусад заалт болон холбогдох журмыг удирдлага болгоно.

13-р зүйл. Гишүүний үүрэг

1. Холбооны гишүүн нь дараах үүрэгтэй. Үүнд:
 - 1.1 ОУХБХ, АХБХ, МХБХ болон Холбооны дүрэм журам, заавар болон шийдвэрийг ямагт бүрэн биелүүлэх, хүндэтгэн сахих,
 - 1.2 Шийдвэр гаргах өөрийн эрх бүхий бүтцийн байгууллагуудаа 4 жил тутам сонгох,
 - 1.3 Байгууллагынхаа эрх барих дээд байгууллагын хурлыг жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулах,
 - 1.4 МХБХ болон Холбооноос зохион байгуулах тэмцээн болон спортын бусад арга хэмжээнд оролцох,
 - 1.5 Олон Улсын Хөлбөмбөгийн Холбооны Зөвлөлөөс баталсан Тоглолтын Дүрэм ба ОУХБХ-ноос баталсан Футзал, Элсний хөлбөмбөгийн Дүрмүүдийг сахиж мөрдөх,
 - 1.6 ОУХБХ-ны дүрэм ба энэхүү дүрэмд заасны дагуу ОУХБХ, АХБХ болон Холбооны дүрэм, журам, заавар болон шийдвэртэй холбогдох тухайн гишүүн буюу өөр гишүүнийг хамарсан аливаа маргааныг Спортын Арбитрт шийдвэрлүүлэх,
 - 1.7 Удирдах зөвлөлөөс хүлээн зөвшөөрөөгүй болон гишүүнчлэлийг нь түдгэлзүүлсэн эсвэл гишүүнээс чөлөөлөгдсөн байгууллага, хувь хүмүүстэй спортын харилцааг тогтоохгүй байх,

- 1.8 Шударга тоглолтын илэрхийлэл болсон тууштай үнэнч, эв нэгдэл, спортын сахилгын зарчмуудыг мөрдөх,
 - 1.9 Гишүүний татвараа төлөх,
 - 1.10 Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг жил тутам заасан хугацаанд ирүүлэх,
 - 1.11 ОУХБХ, АХБХ, МХБХ болон Холбооны Дүрэм, журамд заасан бусад үүрэг.
2. Дээр дурдсан үүргийг зөрчсөн гишүүнд энэ дүрмийн дагуу шийтгэл ногдуулна.

14-р зүйл. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх

1. Холбооноос зохион байгуулдаг үйл ажиллагаанд Давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар нэг жил оролцоогүй тохиолдолд гишүүнчлэлийг түдгэлзүүлэх бөгөөд Холбооны гишүүдийн хуралд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Гишүүн уг үүргээ биелүүлтэл тухайн гишүүний төлөөлөл нь сонгогдох ба томилогдох эрх эдлэхгүй болно.
2. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх асуудлыг Холбооны гишүүдийн хурал шийдвэрлэнэ. Гишүүн үүргийн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд Зөвлөл гишүүнчлэлийг түр түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно. Ийнхүү түр түдгэлзүүлсэн шийдвэрийг Зөвлөл цуцлаагүй тохиолдолд Холбооны гишүүдийн хурал хүртэл хүчинтэй хэвээр байна.
3. Гишүүнчлэлийг түр түдгэлзүүлснийг Холбооны гишүүдийн хурлаар хуралд оролцсон, санал өгөх эрхтэй нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар баталгаажуулна. Ийнхүү баталгаажуулаагүй тохиолдолд гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн нь цуцлагдана.
4. Холбооны бусад гишүүд гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн гишүүнтэй спортын чиглэлээр харилцаа хөгжүүлэхгүй.

15-р зүйл. Гишүүнээс чөлөөлөх

1. Холбооны гишүүдийн хурлаар дараах шалтгаанаар гишүүнийг чөлөөлнө. Үүнд:
 - 1.1 Холбооны өмнө хүлээсэн санхүүгийн үүргээ биелүүлээгүй,
 - 1.2 ОУХБХ, АХБХ, МХБХ болон Холбооны дүрэм, журам, заавар, шийдвэрийг ноцтойгоор зөрчсөн,
 - 1.3 ОУХБХ, АХБХ болон Холбооны холбогдох эрх зүйн актад тусгайлан зааснаас бусад тохиолдолд маргаантай асуудлаар Шүүхэд хандсан тохиолдолд,
 - 1.4 Энэ дүрмийн 14 дүгээр зүйлд заасны дагуу түдгэлзүүлсэн гишүүн нь дараагийн Холбооны гишүүдийн хурал хүртэл зөрчлийг арилгаагүй нь Гишүүнээс чөлөөлөх үндэслэл болно.
2. Гишүүнчлэлийг чөлөөлөх асуудлыг Холбооны гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.
3. Гишүүнчлэлээс чөлөөлөх асуудлыг Холбооны гишүүдийн ирц олонх (50 хувиас дээш) байж хэлэлцэх бөгөөд шийдвэр нь гишүүдийн гуравны хоёрын саналаар хүчин төгөлдөр болно.

16-р зүйл. Гишүүнчлэлээс татгалзах

1. Гишүүн нь гишүүнчлэлээс өөрөө татгалзаж болох ба энэ шийдвэр нь тухайн оны хөлбөмбөгийн улирлын төгсгөлд хэрэгжиж эхэлнэ. Холбооны гишүүнээс татгалзах өргөдлөө Хөлбөмбөгийн улирал дуусахаас 6 сарын өмнө Холбооны нарийн бичгийн даргад хүргүүлсэн байна.
2. Холбоо болон бусад гишүүдийн өмнө хүлээсэн санхүүгийн үүргээ дуусгавар болгосон нөхцөлд Холбооны гишүүнчлэлээс татгалзах асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

III. ХҮНДЭТ ТЭРГҮҮН БОЛОН ХҮНДЭТ ГИШҮҮД

17-р зүйл. Хүндэт тэргүүн болон Хүндэт гишүүд

1. Холбооны гишүүдийн хурлаас тухайн орон нутагт хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэх үйлсэд онцгой гавьяа байгуулсан хувь хүнд Хүндэт тэргүүн буюу Хүндэт гишүүний цол өргөмжлөлийг олгоно.
2. Зөвлөл энэ цол өргөмжлөлд нэр дэвшүүлнэ.
3. Хүндэт тэргүүн эсвэл Хүндэт гишүүд Холбооны гишүүдийн хурал, хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

IV. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

18-р зүйл. Холбооны бүтэц, зохион байгуулалт

1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Холбооны гишүүдийн хурал байна.
2. Зөвлөл нь Холбооны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тогтоож, холбооны хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөт ажлыг удирдан зохион байгуулах эрх бүхий гүйцэтгэх байгууллага байна.
3. Тэргүүн нь Холбоог хууль ёсоор төлөөлнө.
4. Нарийн бичгийн дарга Холбооны захиргааны ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
5. Сахилга, Ёс зүйн хороо болон Маргаан таслах хорооны үйл ажиллагаа нь Эрх зүйн байгууллагад хамаарна.
6. Сонгуулийн хороо нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах болон хяналт тавих эрх бүхий байгууллага мөн.
7. Холбоо нь өөрийн үйл ажиллагааны үндсэн зорилгоо биелүүлэхэд шаардлагатай байнгын болон түр хороо байгуулан ажиллаж болно.
8. Холбооны бүтцийн байгууллагын гишүүд нь Монгол улсын хууль дүрмийн дагуу ямарваа нэг ял, шийтгэл эдэлж байгаагүй этгээд байна.
9. Холбооны бүтцийн зураг Хавсралт №2-т заасны дагуу байна

A. ХОЛБООНЫ ГИШҮҮДИЙН ХУРАЛ

19-р зүйл. Холбооны гишүүдийн хурал

1. Холбооны гишүүдийн хурал нь энэ дүрмийн 10 дугаар зүйлд заасан төлөөллөөс бүрдэх ба Холбооны гишүүдийн тогтмол хуралддаг эрх барих дээд байгууллага байна. Тус дүрмийн дагуу хуралдсан гишүүдийн хурлын шийдвэр нь хүчин төгөлдөр байна.
2. Холбооны гишүүдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Холбооны гишүүдийн ээлжит хурлыг жил бүр зарлан хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн хурлын шийдвэрээр ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.
3. Холбооны гишүүдийн хурлын үйл ажиллагааг Их хурлын хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Тэргүүн даргалан хуралдуулна.
4. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас цахим хэлбэрээр хуралдаж болно. Харилцаа холбооны аргаар, телеконференц, видео хурал хэлбэрээр явагдах үед онлайн саналыг хүчин төгөлдөрт тооцно. Сонгуультай жилийн Холбооны гишүүдийн хурлыг цахимаар зохион байгуулахгүй.
5. Холбооны гишүүдийн хурал нь ардчилсан, хөлбөмбөг дэх хүйсийн эрх тэгш байдлыг хангасан зарчмыг баримтална.
6. Гишүүн бүр хурлын санал хураалтад тэгш эрхтэй оролцох буюу саналын нэг эрхтэй байна.
7. Холбооны гишүүдийн хуралд Холбоонд бүртгэлтэй нийт гишүүдийн 50% нь оролцсон тохиолдолд хурлын ирцийг хүчинтэйд тооцох ба энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсон нийт гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэр гарна.

8. Холбооны Зөвлөл болон Нарийн бичгийн дарга нь Холбооны гишүүдийн хуралд санал өгөх эрхгүй оролцоно.

20-р зүйл. Холбооны гишүүдийн хурлын бүрэн эрх

1. Холбооны гишүүдийн хурал дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
 1. Холбооны Дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
 2. Өмнөх хурлын тэмдэглэлийг хянах, батлах 3 гишүүнийг томилох;
 3. Холбооны Зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;
 4. Эрх зүйн байгууллагуудын дарга болон гишүүдийг сонгох;
 5. Тооллогын комиссын гишүүдийг томилох;
 6. Санхүүгийн тайланг батлах;
 7. Төсөв батлах;
 8. Ажлын тайланг батлах;
 9. Зөвлөлийн саналын дагуу Холбооны гишүүдийн татварын хэмжээг тогтоох;
 10. Зөвлөлөөс Хүндэт тэргүүн, Хүндэт гишүүн цол өргөмжлөл олгохоор нэр дэвшүүлсэн саналыг шийдвэрлэх;
 11. Сонгуулийн хорооны гишүүдийг сонгох ба чөлөөлөх;
 12. Гишүүнээр элсүүлэх, гишүүнээс түдгэлзүүлэх, чөлөөлөх болон татгалзах асуудлыг шийдвэрлэх;
 13. Холбоог татан буулгах;
 14. Гишүүнээс гаргасан хүсэлтийг Дүрмийн дагуу шийдвэрлэх.

20-р зүйл. Холбооны гишүүдийн хурлын ирц, шийдвэр

1. Их Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн ирц олонх (50 хувиас дээш)-ид хүрсэн тохиолдолд Их Хурлаас гарах шийдвэр хүчин төгөлдөр байна.
2. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд саналыг илээр буюу цахим төхөөрөмжөөр хураана. Ил санал хураалтаар олонх болсон гэж тодорхойлоход хүндрэлтэй байвал Хурлын төлөөлөгчдийн нэрсийг цагаан толгойн дарааллын дагуу дуудаж санал хураана.
3. Олонх болсныг тогтоохдоо хоосон ба хүчингүй болсон, түдгэлзсэн саналын хуудас болон цахим төхөөрөмжөөр будлиан үүсгэсэн саналыг хасч тооцно.

21-р зүйл. Сонгууль

1. Сонгуулийг нэр дэвшүүлж явуулна. Сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Нэр дэвшигчийн тоо мандатын тоотой тохирсон тохиолдолд нэр дэвшигчдийг карт эсвэл гар өргөж сонгоно.
2. Холбооны сонгууль, Холбооны гишүүдийн сонгуулийг дүрэмд өөрөөр заагаагүй бол МХБХ-ны Сонгуулийн дүрмийн дагуу явуулна.

22-р зүйл. Холбооны гишүүдийн Ээлжит Хурал

1. Холбооны гишүүдийн Ээлжит Хурал жил тутам хуралдана.
2. Ээлжит Хурал болох өдөр, газрыг Зөвлөлөөс товлоно. Их Хурлын зарыг хуралдахаас 30 хоногийн өмнө гишүүдэд албан ёсоор мэдэгдэнэ.
3. Гишүүд Их Хурлаар хэлэлцүүлэх аливаа саналаа бичгээр товч тайлбарын хамт Ерөнхий нарийн бичгийн газарт Их Хурал болохоос 20 хоногийн өмнө ирүүлнэ.

4. Их Хурал болохоос 10 хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудал, ажлын тайлан, санхүүгийн болон аудитын тайлан, бусад холбогдох бичиг баримтыг Холбооны гишүүдэд хүргүүлнэ.

28-р зүйл. Холбооны гишүүдийн Ээлжит хурлаар хэлэлцэх асуудал

1. Холбооны нарийн бичгийн дарга нь Зөвлөл болон гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэж Холбооны гишүүдийн Ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулна.
2. Холбооны гишүүдийн Ээлжит хурал дараах асуудлыг дарааллын дагуу хэлэлцэнэ. Үүнд:
 - 2.1. Холбооны гишүүдийн хурлыг Холбооны дүрмийн дагуу хүчин төгөлдөр болж буйг мэдэгдэх;
 - 2.2. Хэлэлцэх асуудлыг батлах;
 - 2.3. Тэргүүн үг хэлэх, ажлын тайлан танилцуулах;
 - 2.4. Хурлын тэмдэглэл хянах гишүүдийг /3/ томилох;
 - 2.5. Тооллогын комиссын гишүүдийг /3/ томилох;
 - 2.6. Гишүүнээс түдгэлзүүлэх болон чөлөөлөх тухай асуудал;
 - 2.7. Өмнөх хурлын тэмдэглэлийг батлах;
 - 2.8. Санхүүгийн тайланг батлах;
 - 2.9. Гишүүнээр элсүүлэх;
 - 2.10. Төсөв батлах;
 - 2.11. Холбооны дүрэм, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал хураах, батлах;
 - 2.12. Холбооны байгууллагыг татан буулгах /шаардлагатай бол/;
 - 2.13. Тэргүүн, Зөвлөлийн гишүүдийг сонгох /шаардлагатай бол/;
 - 2.14. Эрх зүйн байгууллагуудын гишүүдийн сонгох, чөлөөлөх /шаардлагатай бол/;
 - 2.15. Сонгуулийн хорооны гишүүдийг сонгох /шаардлагатай бол/.
3. Хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй зүйлийг Холбооны Гишүүдийн хурал хэлэлцэхгүй. Гэхдээ санал өгөх эрхтэй төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар Хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулан хэлэлцэж болно.

29-р зүйл. Холбооны гишүүдийн ээлжит бус хурал

1. Зөвлөл шаардлагатай тохиолдолд Холбооны гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулж болно.
2. Холбооны гишүүдийн гуравны хоёроос дээш гишүүдийн албан ёсоор ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Зөвлөл Холбооны гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулна. Гишүүд тавьсан хүсэлтдээ хэлэлцэх асуудлыг тодорхой заана.
3. Хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн хугацаанд ээлжит бус хурлыг хуралдуулна. Хэрэв ээлжит бус хурлыг хуралдуулахгүй тохиолдолд хүсэлт гаргасан гишүүдийн төлөөлөгчид өөрсдөө ээлжит бус хурлыг хуралдуулж болно.

30-р зүйл. Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Холбооны гишүүдийн хурал нь дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хариуцна.
2. Гишүүд болон Зөвлөл холбооны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа бичгээр гаргаж үндэслэлийн хамт нарийн бичгийн даргын газарт хүргүүлнэ.
3. Холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал нь хуралд оролцсон, санал өгөх эрхтэй нийт гишүүдийн гуравны хоёр ба түүнээс дээш саналаар дэмжигдэж батлагдана.

Б. ЗӨВЛӨЛ

31-р зүйл. Зөвлөлийн бүрэлдэхүүн

1. Зөвлөл нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээрийг 4 жилийн хугацаатайгаар Холбооны гишүүдийн хурлаас сонгоно.
2. Зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
 - Холбооны Тэргүүн
 - Гишүүд
3. Зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдах бөгөөд Зөвлөлийн хурлыг Холбооны Тэргүүн зарлан хуралдуулж даргална.
4. Хуралд нийт гишүүдийн 50-иас дээш хувь ирсэн тохиолдолд хурлын ирцийг хүчинтэйд тооцно. Хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхи /50%-иас дээш/-ийн саналаар Зөвлөлийн шийдвэрийг батална.
5. Зөвлөлийн гишүүн нь 18-аас дээш настай байх бөгөөд хөлбөмбөгийн спортод 2-оос доошгүй жил идэвхтэй оролцсон, Монгол улсын хууль тогтоомжийг зөрчиж, гэмт хэрэгт холбогдоогүй, тус аймгийн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэн байна.
6. Зөвлөлийн гишүүн нь нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан эсвэл хуралдаанд гурван удаа дараалан оролцоогүй бол гишүүний бүрэн эрх дуусгавар болсонд тооцно.

32-р зүйл. Хуралдаан

1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаан нь ээлжит болон ээлжит бус байна.
2. Зөвлөлийн ээлжит хуралдаан нь улиралд нэг удаа хуралдана. Тэргүүн ээлжит хуралдааныг зарлан хуралдуулж даргална. Зөвлөлийн ээлжит бус хурлыг нийт гишүүдийн 50 хувь нь хуралдаан зарлах хүсэлт гаргасан тохиолдолд Тэргүүн 14 хоногийн дотор хуралдааныг зарлан хуралдуулна.
3. Тэргүүн хуралдааны хэлэлцэх асуудлыг тодорхойлно. Зөвлөлийн гишүүн бүр хэлэлцэх асуудлын талаар санал өгөх эрхтэй.
4. Нарийн бичгийн дарга Зөвлөлийн хуралдаанд зөвлөх үүрэгтэй оролцох ба хуралдааны тэмдэглэл хөтлөх, тогтоолыг бэлтгэн батлуулна.

33-р зүйл. Зөвлөлийн бүрэн эрх

1. Зөвлөл нь Холбооны эрхэм зорилго, бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно;
2. Холбооны Ээлжит болон Ээлжит бус хурлын бэлтгэлийг хангаж хуралдуулна;
3. Тэргүүний санал болгосноор Нарийн бичгийн даргыг томилох эсвэл чөлөөлөх;
4. Холбооны тэмцээнүүдийн зохион байгуулалт ба тэдгээрт оролцох нөхцлийг зааж өгсөн журмыг гаргана. Энэ нь гишүүдийн хурлын бүтэц, зохион байгуулалтад нөлөөлөхгүй байна;
5. Аймгийн шигшээ багийн дасгалжуулагч болон техникийн бүрэлдэхүүнийг томилох;
6. Аймгийн холбооны дотоод бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлсон журам батлах;
7. Холбооны Дүрмийн хэрэгжилтийг хангуулах, түүнийг хэрэгжүүлэхэд авах шаардлагатай арга хэмжээг батлах;
8. Ээлжит хурал хүртэл түр хугацаагаар гишүүнчлэлийг түдгэлзүүлэх;
9. Холбооны гишүүдийн хурлын хэлэлцүүлэгт санал өгөх эрхгүйгээр оролцох.

34-р зүйл. Зөвлөлийн шийдвэрүүд

1. Зөвлөлийн хуралдааны ирц олонх /50 хувиас дээш/-д хүрсэн тохиолдолд хурлын ирц хүчинтэйд тооцогдоно.
2. Зөвлөлийн шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар (50 хувиас дээш) батална. Санал тэнцсэн үед тэргүнний саналаар шийдвэрлэнэ. Санал өгөх эрхийг бусдад шилжүүлэх эсвэл албан бичгээр өгөхийг үл зөвшөөрнө.
3. Хуралдаанаас гарсан шийдвэрүүдийг хурлын тэмдэглэлд тусгана.

В. ТЭРГҮҮН

35-р зүйл. Тэргүүн

1. Тэргүүн нь Холбоог албан ёсоор төлөөлнө. Тэргүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Тэргүүнийг 1 удаа улируулан сонгож болно.
2. Холбооны гишүүдийн хурал, Зөвлөлийн хурлыг дэгийн дагуу даргалж оролцоно.
3. Нарийн бичгийн даргыг томилох эсвэл чөлөөлөх асуудлыг Зөвлөлд санал болгоно.
4. Тэргүүний нэн тэргүүнд хариуцах асуудлууд. Үүнд:
 - 4.1. Гишүүдийн хурал болон Зөвлөлөөс гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлнэ.
 - 4.2. Энэхүү Дүрмийн зорилтуудыг биелүүлэхийн тулд Холбооны байгууллагууд нь үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулж буй эсэхэд хяналт тавина.
 - 4.3. Нарийн бичгийн даргын ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавина.
 - 4.4. Холбоо гишүүн байгууллагууд, ОУХБХ, АХБХ, МХБХ, төрийн болон төрийн бус байгууллага хоорондын харилцааг хариуцна.
5. Тэргүүн нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан аль эсвэл Зөвлөлийн хуралдаанд нэг жилд 3 удаа оролцоогүй тохиолдолд Тэргүүний албан тушаал чөлөөлөгдсөнд тооцно.

Г. НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

36-р зүйл. Нарийн бичгийн даргын эрх, үүрэг

1. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг Холбооны дүрэмд заасны дагуу зохион байгуулна.
2. Холбооны захидал харилцааг хариуцах ба МХБХ-той байнгын харилцаа холбоо тогтоож, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулна.
3. Тэргүүний эзгүйд түүний үүргийг гүйцэтгэнэ.
4. МХБХ-ноос зохион байгуулж буй тэмцээнд баг, клубуудыг бүртгүүлэн оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулна.
5. МХБХ-ноос зохион байгуулж буй уулзалт сургалтад төлөөлөгчдөө хамруулах ажлыг зохион байгуулна.
6. Нарийн бичгийн даргыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр томилох бөгөөд тэрээр зохих мэргэжлийн шаардлагыг хангасан, дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
7. Холбооны гишүүдийн хурал болон Зөвлөлийн хуралдаанд оролцох, хурлын бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах, хурлын тэмдэглэлийг хариуцах, гарсан шийдвэрийг Тэргүүний чиглэлийн дагуу хэрэгжүүлнэ.
8. Холбооны нягтлан бодох бүртгэлийг ОУХБХ, АХБХ, МХБХ-ны нягтлан бодох бүртгэлийн дагуу зөв хөтөлнө.

9. Нарийн бичгийн даргын газрын бүтэц, зохион байгуулалтыг хариуцна.
10. Нарийн бичгийн дарга нь Холбооны аль нэг байгууллагад гишүүн байж үл болно.

Д. СОНГУУЛИЙН ХОРОО

37-р зүйл. Сонгуулийн хороо

1. Тус хороо нь Холбооны сонгуулийг МХБХ-ны Сонгуулийн дүрмийн дагуу зохион байгуулж, хяналт тавина.

V. САНХҮҮ

38-р зүйл. Санхүүгийн жил

1. Холбооны санхүүгийн тайланг хугацаа нэг жил байх бөгөөд тухайн жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхэлж, арван хоёрдугаар сарын 31-ний өдрөөр дуусна.
 2. Санхүүгийн тайланг хугацаанд орлого зарлагыг тэнцвэржүүлэх менежментийг хийнэ. Холбооны цаашдын үйл ажиллагааны баталгаа болгож нөөц хөрөнгөтэй болох чиглэлийг баримтална.
 3. Нарийн бичгийн дарга нь Холбооны санхүүгийн нэгдсэн тайланг тухайн жилийн арван хоёрдугаар сарын 31-ний дотор гаргаж, МХБХ-ны дүрэмд заасны дагуу МХБХ-нд зохих ёсоор тайлагнана. Энэхүү үүргийг зөрчсөн тохиолдолд МХБХ-ноос зохих санхүүгийн шийтгэлийг ногдуулна.
-

39-р зүйл. Орлого

1. Холбооны орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 1.1. МХБХ-ноос ирүүлж буй санхүүжилт;
 - 1.2. Гишүүнчлэлийн татвар;
 - 1.3. Холбооны маркетингийн ашиг;
 - 1.4. Холбооны зорилтыг биелүүлэхтэй холбоотой татвар хураамж;
 - 1.5. Хандив;
 - 1.6. Хөлбөмбөгийн үйл ажиллагаатай холбоотой олж буй бүхий л орлого.
-

40-р зүйл. Зарлага

1. Холбооны зардал дараах төрөлтэй байна:
 - 1.1. Төсвийн зардал;
 - 1.2. Гишүүдийн хурал ба Зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд батлагдсан бусад зардал;
 - 1.3. Холбооны зорилтыг биелүүлэхтэй холбоотой шаардлагатай бусад зардал.
 2. Холбоо нь санхүүгийн орлогыг зөвхөн өөрийн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулж зарцуулна.
-

41-р зүйл. Гишүүний татвар

1. Гишүүний татварыг жил бүрийн нэгдүгээр сарын 31-ний дотор төлсөн байна. Шинэ гишүүд тухайн жилийн татварыг, гишүүнээр элссэн гишүүдийн хурлаас хойш 30 хоногийн дотор төлнө.
2. Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэж, Их Хурал нь гишүүний татварын хэмжээг 4 жилд нэг удаа тогтооно. Гишүүн бүр ижил хэмжээний татвар төлөх ба татвар нь 50,000 төгрөг байна.

42-р зүйл. Хураамж

1. Холбоо нь тоглолтын хураамж төлөхийг гишүүдээс шаардаж болно.
2. Холбоо нь банкинд албан ёсны харилцах данстай байх бөгөөд Нарийн бичгийн дарга холбооны хөрөнгө, санхүүг МХБХ-ны дүрэмд заасны дагуу захиран зарцуулна.

VI. ТЭМЦЭЭН

43-р зүйл. Тэмцээнүүд

1. Холбоо нь аймгийн нутаг дэвсгэрт албан ёсны дараах тэмцээнүүдийг МХБХ-той хамтран эсвэл дангаар зохион байгуулна:
 - 1.1. Аймгийн аварга шалгаруулах тэмцээн;
 - 1.2. Аймгийн эмэгтэйчүүдийн аварга шалгаруулах тэмцээн;
 - 1.3. Өсвөр ба Идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн;
 - 1.4. Залуучуудын аймгийн аварга шалгаруулах тэмцээн;
 - 1.5. Футзалын бүх насны тэмцээн;
 - 1.6. Эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийн тэмцээн;
 - 1.7. Сонирхогчдын тэмцээн;
 - 1.8. Ахмадын тэмцээн;
 - 1.9. Бүсийн аварга шалгаруулах тэмцээн.
2. Эдгээр тэмцээнүүд нь МХБХ-ноос зохион байгуулж буй тэмцээнүүдтэй давхардсан тохиолдолд МХБХ-ны тэмцээнүүдэд тэргүүн ач холбогдол өгнө.

44-р зүйл. Тэмцээний эрх

1. Холбоо нь өөрийн аймгийн хүрээнд зохион байгуулж буй тэмцээн болон бусад арга хэмжээтэй холбоотой бүхий л эрхийн эзэмшигч байх хэдий ч МХБХ-ны дүрэм, журмыг удирдлага болгоно. Эзэмших эрх дотор санхүүгийн бүхий л төрлийн эрх, дуу дүрс ба радио бичлэг, хувилах ба дамжуулах эрх, мультимедиа эрх, маркетинг ба сурталчилгааны эрх, зохиогчийн эрхийг хамгаалах хуулийн хүрээнд багтсан тухайлбал эмблем гэх зэрэг эрхүүд багтана.
2. Дээрх эрхийг ямар хэмжээнд, хэрхэн яаж эдлэх асуудлыг Зөвлөл шийдвэрлэх бөгөөд уг асуудлаар тусгай журам гаргана.

VII. ТӨГСГӨЛИЙН ЗҮЙЛ

45-р зүйл. Давагдашгүй хүчин зүйлс

1. Давагдашгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд ОУХБХ, АХБХ, МХБХ-ны холбогдох журмын дагуу бодит шийдвэр гаргах эрхийг Зөвлөл эдэлнэ.

46-р зүйл. Татан буулгах

1. Холбоог татан буулгах шийдвэр гаргахад тусгайлан Холбооны гишүүдийн хурлыг хуралдуулж, гишүүдийн гуравны хоёрын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
2. Холбоог татан буулгах нөхцөлд түүний хөрөнгийг хүлээн авах этгээдийг Холбооны гишүүдийн хуралд оролцсон төлөөлөгчдийн гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ.

9-р зүйл. Бусад зүйл

1. Холбоо нь МХБХ-ны дүрэм, журамд нийцүүлэн энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба нэмэлт, өөрчлөлтийг урьдчилан МХБХ-нд танилцуулан, батлуулсан байна.
2. Энэхүү дүрэмд тусгагдаагүй аливаа асуудлыг МХБХ-ны дүрэм, журмын дагуу шийдвэрлэх ба энэхүү дүрмийн заалт нь МХБХ-ны дүрмийн заалттай үл нийцвэл МХБХ-ны дүрмийн заалтаар тухайн маргаантай асуудлыг шийдвэрлэнэ.

10-р зүйл. Хүчин төгөлдөр болох нь

1. Энэхүү Дүрмийгаймгийн хотноо хуралдсанаймгийн Холбооны Холбооны гишүүдийн хурлаар баталж 20.. оны ... –р сарын ...- ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.